

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА

Ц.ТӨРХҮҮ

САГСАН БӨМБӨГИЙН ЗХЗ ТАЛБАЙ БАЙГУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 03-р сарын 28-ны өдөр

Дугаар 2024/01-05

Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/50 дугаар тушаал
2. Барилга байгууламжийн байршил	- Нийтийн эзэмшлийн гудамж талбай
3. Зориулалт хүчин чадал	- Сагсан бөмбөгийн ЗХЗ талбай <ul style="list-style-type: none"> • Сонгинохайрхан дүүрэг 18 дугаар хороо
4. Төслийн иж бүрдэл	Баримт бичиг иж бүрдэл: <ul style="list-style-type: none"> - Тайлбар бичиг - Ажлын тоо хэмжээ - Батлагдах /УБЗАА/ Зураг төслийн иж бүрдэл: <ul style="list-style-type: none"> - Одоогийн байдал /фото зургаар баталгаажуулах/ - Хэмжилтын зураг - Барилгын нэгдсэн төсөв /Магадлалын дүгнэлт/
5. Зураг төсөл боловсруулах үе шат, хугацаа	Ажлын зураг төсөв нэг үе шаттай: <ul style="list-style-type: none"> - Зураг төсөв боловсруулж, зөвшилцэж батлуулах - Захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндсэлэл болгоно.
6. Арчлалт хамгаалалт	Гүйцэтгэсэн ажлыг баталгаат хугацаанд өөрийн хөрөнгөөр засвар, арчлалтыг тогтмол гүйцэтгэнэ.
7. Зураг төслийн байгууллага	Захирамжийн дагуу сонгон шалгаруулалтаар шалгарсан байгууллага
8. Төслийн захиалагч	- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба
9. Хийгдэх тохиижилтүүн ажлууд	Ашиглагч, захиалагчийн хамт газар дээр нь очиж үзэж холбогдох хүмүүстэй зөвшилцэж, төсөвт өртөг багтах хэмжээгээр ажлын зураг төсвийг боловсруулна.
10. Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Төсөл хөтөлбөрүүд:</u> -Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага; -Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал <u>Хууль тогтоомжууд:</u> -Газрын тухай хууль -Барилгын тухай хууль Норм, нормативууд: -Барилгын инженер геологийн ажил /БНБД 11-03-01/ -Барилгын геодизийн ажил /БНБД 11-08-06/


	<p>-Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05</p> <p>-Барилгын бүтээц, ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хавсралтуудыг боловсруулах хэрэглэх дүрэм БНБД 981-10-02</p> <p>-Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм БНБД 81-94-12</p> <p>-Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм</p> <p>-Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12</p> <p>-Хот, тосгоны нутаг дэвсгэр, зам талбайгаас бороо, цасны усыг зайлцуулах ажлын зураг төсөл, тооцооны норм /БД 40-302-13/</p> <p>-Хот суурины гудамж, зам төлөвлөлт /БНБД 32-01-04/</p> <p>-Бусад холбогдох норм, дүрэм;</p> <p><u>Стандартууд:</u></p> <p>-Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага UCS1901B:2020</p> <p>-Хүүхдийн тоглоомын талбай эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага UCS0002-02:2019</p> <p>-Саравч, сүүдэрэвчинд тавигдах ерөнхий шаардлага UCS 1402C:2020</p> <p>-Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах хогны саванд тавигдах шаардлага UCS1403C:2020</p> <p>- Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах сандалд тавигдах шаардлага UCS1403C:2020</p> <p>-Бусад холбогдох стандартууд</p>
11. Онцгой нөхцөл	<p><u>Ажилд тавигдах шаардлага:</u></p> <p>-Тус ажилд ашиглах материалыг сонгохдоо орчин үеийн дэвшилтэд технологи нэвтрүүлсэн. Монгол Улсын стандартад нийцсэн материал байх.</p> <p>-Сагсан бөмбөгийн хашааг 4м-ээс доошгүй өндөртэй, стандартын дагуу чанартай хийж гүйцэтгэх. Хашааны багана, хөндлөн тулаас, тор зэргийг бат бөх материал сонгон хийж гүйцэтгэх.</p> <p>-Сагсан бөмбөгийн талбайн хаалгыг бат бөх нугас холбоостой байхаар гүйцэтгэх.</p> <p>-Сагсан бөмбөгийн талбайн шалны материалыг хуулж авах, гулгалт үүсэхээс сэргийлж бэхэлгээг хийх</p> <p>-Спорт талбайн гэрэлтүүлгийг үндсэн хашаанаас тусдаа шон дээр өндөрийг тооцон хашаанаас өндөрт суурьлуулах. Гэрэлтүүлэг нь зориулалтын прожектор байна.</p> <p>- Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амрах зугаалах, тохижилт бүтээн байгуулалтыг арчлах, хамгаалахад зориулж гар утас болон бусад төхөөрөмжүүдээс хянах бүхий хяналтын камерийг байршуулах</p> <p>-Тоглоомын талбайн тоног төхөөрөмжийг сонгохдоо гарал үүслийн гэрчилгээг хавсаргах, бэхэлгээг сайн хийж гүйцэтгэх</p> <p>-Гүйцэтгэлийн ажил эхлэхээс өмнө захиалагч, авторт нарт мэдэгдэж ажлын хувиарыг танилцуулах.</p> <p>-Зураг төслийг эхлэхдээ талбайд судалгаа хийж фото зураг хавсаргах, дэвсгэр зурагт заавал газар доорх инженерийн шугам сүлжээний тодруулга хийлгэх.</p>
12. Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг ESTIMATOR-PRO программ тооцож ирүүлэх.

13. Бусад

Ажлын үе шат бүрт нэг цэгээс фото зураг авч, далдлагдсан ажил бүр дээр акт бичиж, инженерээр баталгаажуулна.

ХЯНАСАН:

ДУГУЙН БА ЯВГАН ХҮНИЙ ЗАМ, ТОХИЖИЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Г.БИЛГҮҮН

БОЛОВСРУУЛСАН:

ДУГУЙН БА ЯВГАН ХҮНИЙ ЗАМ, ТОХИЖИЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



У.САНЧИР